

Дундговь аймаг дахь
Төрийн аудитын газар



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2024 ОНЫ
БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ”-Д
ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДЭД ТАЙЛАНГИЙН
ХУРААНГУЙ ТАЙЛАН

АУДИТЫН КОД: /ДУА-2025/31/-10-ШТА-ГА/

Дундговь аймаг дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх аудитор
Р.Мөнхтогтох Утас: 70592439
Аудитын менежер: Т.Оюун-Эрдэнэ
Утас: 70592225
Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn
Ахлах аудитор Т.Батсайхан
Аудитор Ж.Угтахбаяр
Аудитор Д.Должинсүрэн
Аудитор Б.Мягмарсүрэн
Утас: 7059-3113

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим
хуудас: www.audit.mn

“ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2024 ОНЫ БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ”-Д ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Нэг. Ерөнхий мэдээлэл

Аудитын код:	ДУА-2025/31-10-ШТА-ГА	Аудитын хамрагдах хугацаа:	2024 он
Аудитын нэр:	“ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2024 ОНЫ БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ”		
Аудит хийсэн бүтцийн нэгжийн нэр:	Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудит хийсэн баг	Аудитын 1-р нэгж

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 онд баталсан “Аудитын сэдэв батлах тухай” А/107, “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаалууд, Дундговь аймгийн Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө.
Аудитын зорилт:	➤ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх; ➤ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх; ➤ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль, журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх.
Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:	➤ Төсвийн тухай хууль ➤ Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль /2020 он/; ➤ Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт; ➤ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль; ➤ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль; ➤ Төрийн хэмнэлтийн тухай ➤ Малын тоо толгойн албан татварын тухай хууль ➤ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль; ➤ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль; ➤ МУ-ын Засгийн газрын 2023 оны 457 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал” ➤ Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам” ➤ Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” ➤ Засгийн газрын 2023 оны 278 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам” ➤ Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжүүд; ➤ Барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд.

Аудитын хамарсан
хүрээ:

Аудитын арга зүй:

Дундговь аймаг, 15 сумдын 2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн тайлан, улсын төсвөөс хуваарилж олгосон шилжүүлэг болон бусад эх үүсвэрээр бүрдүүлсэн хөрөнгийг хэрхэн зарцуулсан талаарх ажлын тайлан, анхан шатны болон НББ-ийн журнал бусад холбогдох материал

АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам (2020 он), Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал

Хоёр. Аудитын үр дүн

А. Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг хууль, журмын дагуу хуваарилсан боловч төвлөрүүлэх боломжтой орлогыг төлөвлөөгүй, бүрдүүлэлт хангалтгүй байна.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 635.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 15,880.4 сая төгрөг болгон баталсан байна.

Хүснэгт №1

Орлогын эх үүсвэрийн нэр	Орлогын дүн	Эзлэх хувь
ОНХНС болон улсын төсвөөс олгосон орлогын шилжүүлэг	13,263.6	83.5
Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	494.1	3.1
Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	1,150.3	7.2
Өмнөх жилийн төлөвлөлт, зарцуулалт, үйл ажиллагааны үнэлгээ	972.3	6.1
Дүн	15,880.4	100.0

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар Дундговь аймагт ОНХНС-аас Төсвийн тухай хуулийн 59.2, 59.3-т заасан хувь, итгэлцүүрийн дагуу /66.6 хувь буюу 10,574.9 сая төгрөгийг сумдад, 33.4 хувь буюу 5,305.5 сая төгрөгийг аймгийн ОНХС-д/ олгохоор баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 46 дугаар тогтоолоор ОНХС-ийн 2024 оны эх үүсвэрийг 23,305.9 сая төгрөгөөр баталсныг 2024 оны 40 дугаар тогтоолоор 22,416.3 сая төгрөг болгон 889.6 сая төгрөгөөр бууруулан тодотгосон байна. Энэ нь ОНХНС-аас аймгийн ОНХС-д хуваарилсан орлогын шилжүүлгийг 635.8 сая төгрөгөөр, зарим сумд өмнөх оны үлдэгдлийг 239.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн ч өмнөх оны үлдэгдэл, малын тоо толгойн албан татвар, хандив тусламжийн орлогыг 1,764.8 сая төгрөгөөр бууруулсантай холбоотой байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 40 дугаар тогтоолоор ОНХНС-аас олгох шилжүүлгээс гадна аймаг, сумдын ОНХС-ийн 2023 оны үлдэгдлээс 4,326.7 сая төгрөг, малын тоо толгойн албан татварын орлогоос 1,285.3 сая төгрөг, тусгай зөвшөөрөл эзэмшигч, нутгийн захиргааны байгууллагатай байгуулсан гэрээний дагуу олгосон хандив, тусламжийн орлогоос 865.0 сая төгрөг, бусад орлогоос 58.9 сая төгрөг төвлөрүүлэхээр баталсан байна.



Аймгийн ОНХС-аас сумдад олгох орлогын шилжүүлэгт 10,574.9 сая төгрөгийг хуваарилахаас 10,164.9 сая төгрөгийг олгосон байна. Орлогын шилжүүлгийг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл, газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлого улсын төсөвт дутуу төвлөрсөнтэй холбоотой 410.1 сая төгрөгөөр дутуу олгосон байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.5¹-т заасны дагуу хандив, тусламж, урамшууллаас аймгийн ОНХС болон Баянжаргалан, Дэлгэрцогт сумд 865.0 сая төгрөгийг төвлөрүүлэхээр баталж, 317.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Харин бусад сумд тус орлогын эх үүсвэрийг төлөвлөөгүй, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна. Тухайлбал Баянжаргалан сум уул, уурхайн компаниас авсан хандив, замын хураамжийн орлого, Сайнцагаан, Луус, Дэрэн, Гурвансайхан, Адаацаг сумд “Ю ПИ СИ МАНДАЛГОВЬ ЭНЕРЖИ” ХХК-тай нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажиллах гэрээ байгуулалгүй 405.0 сая төгрөгийн хандивыг ОНХС-ийн дансанд төвлөрүүлээгүй төрийн бус байгууллагаар дамжуулан авч зарцуулсан зөрчил илэрснийг дараах байдлаар шийдвэрлэсэн. Үүнд:

- Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланг баталгаажуулах аудитаар өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй Баянжаргалан сумын Засаг даргад хариуцлага тооцуулах саналыг аймгийн Засаг даргад хүргүүлсэн;
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн гүйцэтгэлийн аудитаар төрийн бус байгууллагаар дамжуулан зарцуулсан 405.0 сая төгрөгийн зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх саналыг Монгол Улсын Ерөнхий Аудиторт хүргүүлсэн.

Говь-Угтаал, Эрдэнэдалай, Өлзийт сумд аймгийн ИТХ-аас баталсан ОНХС-ийн орлогын шилжүүлгийг 15.0 сая төгрөгөөр математик тооцооллын алдаатай баталсан. Харин Цагаандэлгэр сум аймгаас олгох орлогын шилжүүлгийг 80.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгол хийгдсэн байхад эх үүсвэрийг нэмж, хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг батлаагүй байна. Энэ нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ны эх үүсвэр дутагдаж, эргэлтэд орохгүй байх, ИТХ-аар баталсан ТАХ хэрэгжихгүй орхигдох үр дагаврыг бий болгож байна

Аймгийн хэмжээнд Орон нутгийн хөгжлийн сангийн орлогыг бүрэн төлөвлөөгүй, биелэлтийг хангаж ажиллахгүй байгаа нь тус сангийн хөрөнгийн эх үүсвэр дутагдах, төлөвлөсөн төсөл, арга хэмжээ цаг хугацаандаа бүрэн хэрэгжихгүй байх эрсдэлийг бий болгож байна.

Иймд аймаг, сумд ОНХС-ийн эх үүсвэрийг нэмэгдүүлж болох орлогыг хуульд заасан нэр төрөл тус бүрээр судалж, дүн шинжилгээ хийж төлөвлөх, сангийн орлогыг нэмэгдүүлэхэд санаачилга гарган ажиллаж, орлогыг бүрэн төвлөрүүлж, төсөл, арга хэмжээний эх үүсвэрийг бий болгох шаардлагатай байна.

2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, ТАХ-ний төлөвлөлтөд аймгийн хэмжээнд 15 сумын 14,875 өрхөөс давхардсан тоогоор 73,683 саналыг авч, ОНХС-ийн удирдлага мэдээллийн системт оруулжээ.

Иргэдээс ОНХС-гийн хөрөнгөөр **1,790** хөрөнгө оруулалт ТАХ-г санхүүжүүлэхээр санал ирүүлснээс **359** нь батлагдаж, **1,431** нь эрэмбээс хасагдсан байна.

Тайланд онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө 73,683 санал авсан нь өмнөх оноос 8.4 дахин өссөн боловч иргэдийн саналаар дэмжигдээгүй, эрэмбэлээгүй ТАХ-г төлөвлөсөн зөрчлүүд арилахгүй байна.

ОНХС-гийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх **22,333.2** сая төгрөгийн өртөг бүхий **364** ТАХ-ээс **3,151.2** сая төгрөгийн **71** ТАХ-г батлахдаа дараах шаардлагуудыг хангаагүй байна. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлд тусгагдаагүй,
- Иргэдийн саналаар дэмжигдээгүй, санал авч эрэмбэлэгдээгүй,
- Зураг төсөвгүй, ТЭЗҮ-гүй,
- Ашиглалтын дараах урсгал зардлыг тооцоолоогүй,
- Магадлалаар баталгаажаагүй,
- Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдээгүй.

Иймд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх хугацаатай албан шаардлагуудыг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлээ.

1 тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг

Б. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ үр нөлөөтэй байна.

Дундговь аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд нийт 22,333.2 сая төгрөгийн өртөгтэй 364 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээс нийт төсвийн 75.6 хувь буюу 16,888.5 сая төгрөгийн 251 ТАХ-нд сонгон шалгаруулалт зарлаж, худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ.

Худалдан авах үйл ажиллагаа явуулсан ТАХ-г сонгон шалгаруулалтаар нь авч үзвэл 15.9 хувь буюу 40 ажлыг нээлттэй тендер, 19.9 хувь буюу 50 ажлыг харьцуулалтын арга, 62.9 хувь буюу 158 ажлыг шууд худалдан авалтын арга, 0.8 хувь буюу 2 ажлыг олон нийтийн оролцоотой худалдан авалт, 0.5 хувь буюу 1 ажлыг Нэг эх үүсвэрээс худалдан авах аргыг ашиглан зохион байгуулсан байна.

Гүйцэтгэлээр нээлттэй тендер шалгаруулалтаар шалгарсан 8,627.0 сая төгрөгийн 39 ТАХ-г хэрэгжүүлж, 1 ТАХ-г шилжих хөрөнгөөр он дамжуулан хэрэгжүүлэхээр гэрээнд өөрчлөлт оруулсан байна. Харьцуулалтын аргаар шалгарсан 2,317.7 сая төгрөгийн 49 ТАХ-г хэрэгжүүлж, 1 ТАХ-г багц болгон хувааж, шууд худалдан авалт хийсэн байна. Шууд худалдан авалтын 161 ТАХ-г 2,173.3 сая төгрөгөөр, ОНОХА-уудын 2 ТАХ-г батлагдсан төсвөөс 43.0 сая төгрөгөөр бууруулан гэрээг байгуулсан байна.

Аймаг болон сумдын орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар босго үнэ мөрдөлгүй, худалдан авах аргыг буруу сонгосон, төсөвт өртөг нь 100.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй төсөл арга хэмжээний тендерийн баримт бичигт гүйцэтгэлийн болон чанарын баталгааг тусгаж, баталгаа хийлгээгүй зөрчлүүд илэрсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10.3², 10.12³, 42.1⁴, 42.2⁵ дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд ОНХС-ийн хөрөнгийн худалдан авах ажиллагааг үр дүнтэй, хуулийн дагуу зохион байгуулаагүй сумдын Засаг дарга нарт зөрчлийг арилгаж, хуулийн дагуу ажиллах хугацаатай албан шаардлага хүргүүлсэн байна.

Харин гүйцэтгэлийн аудитаар сумдын худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэхийг шалгахад:

- “Эрдэнэдалай” сумын ИТХ-ын тогтоолоор батлагдсан 19.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй арга хэмжээг 0.2 сая төгрөгөөр илүү дүнгээр “Эрүүл мэндийн төвийн хэвтэн эмчлүүлэгчийн орыг нэмэгдүүлэх” гэрээг шууд худалдан авалтаар байгуулж, төлбөрийг олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2 Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” -ын 4 дүгээр зүйлийн 4.3.6 заалтуудыг тус тус зөрчсөн байна.
- Өлзийт сумын ОНХС-аар хийгдсэн 527.4 сая төгрөгийн өртөгтэй “Сургуулийн 1-р дотуур байрны их засвар” ТАХ-ний гадна хаяавч бүрэн хийгдэж, дуусаагүй байхад засварын ажлыг хүлээн авч, гүйцэтгэлийн санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Иймд гүйцэтгэлийн аудитаар илэрсэн дээрх зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлагыг Эрдэнэдалай сумын Засаг даргад, өмнөх аудитаар өгөгдсөн “ОНХС-ийн 100 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тендерийн баримт бичигт гүйцэтгэлийн болон чанарын баталгааг тусгаж байгаа эсэхэд хяналт тавьж, худалдан авах ажиллагааг үр дүнтэй, хуулийн дагуу зохион байгуулах” зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчил давтан гарсан тул аймгийн Засаг даргад тус тус хүргүүлээ.

Тайлант онд хэрэгжих төсөл, арга хэмжээнээс 5,604.6 сая төгрөгийн 113 ТАХ-ний худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулаагүй, 3 ТАХ-ний гэрээ цуцлагдан хэрэгжээгүй байна.

² /Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно;/

³ /Энэ хуулийн 10.2, 34.1-д заасан төсөвт өртгийн дээд хязгаарыг Засгийн газар тогтооно./

⁴ /Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана./

⁵ /Захиалагч гүйцэтгэлийн баталгааны дүнг тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувиар тогтоож тендер шалгаруулалтын баримт бичигт тусгана. /

Аймгийн хэмжээнд 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр нийт 13,886.0 сая төгрөгийн 252 ТАХ хэрэгжсэнээс 26.8 хувь буюу 3,716.1 сая төгрөгийг иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, шинжлэн ухаан, цахим технологид, 30.1 хувь буюу 4,184.7 сая төгрөгийг дэд бүтцийг сайжруулах, зам, гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээнд, 20.8 хувь буюу 2,881.8 сая төгрөгийг орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалахад, 4.2 хувь буюу 589.1 сая төгрөгийн ундны усан хангамж, эрүүл ахуйг сайжруулахад, 8.1 хувь буюу 1,118.0 сая төгрөгийг аймаг, хотын хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв, боловсруулахад, 4.6 хувь буюу 637.4 сая төгрөгийг ажлын байр бий болгох, өрхийн орлого нэмэгдүүлэхэд, 5.1 хувь буюу 713.9 сая төгрөгийг малын тоо толгойн албан татварын орлогын эх үүсвэрээр хэрэгжүүлэх ТАХ буюу хөдөө аж ахуйн салбарт, 0.3 хувь буюу 45.0 сая төгрөгийг журамд заасан чиг үүрэгт хамааралгүй зардалд зарцуулсан байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар сумын ИТХ-аар батлаагүй, зориулалт бус, сангийн хөрөнгийг илүү олгосон дараах зөрчлүүд илэрсэн.

1. Гурвансайхан, Луус, Адаацаг сумдад илүү олгож, хууль зөрчсөн зөрчлүүд илэрснийг төлбөрийн акт тогтоож, буцаан төлүүлэхээр болсон.
2. Цагаандэлгэр, Эрдэнэдалай сумд ИТХ-ийн тогтоолоор батлагдаагүй, зориулалт бус зардалд зарцуулсан зөрчлийг таслан зогсоох хугацаатай албан шаардлагыг хүргүүлсэн байна.

Харин гүйцэтгэлийн аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ төлөвлөсөн зорилтод түвшин, үр ашиг, үр дүнд хүрсэн эсэхийг шалгахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Сайнцагаан, Эрдэнэдалай, Өлзийт сумдын ОНХС-ийн зөвлөх үйлчилгээ;
2. Өлзийт сумын 12.4 сая төгрөгийн өртөгтэй Цаг уурын барилгын зураг төсөв;
3. Говь-Угтаал сумын ОНХС-ийн хөрөнгөөр 13.0 сая төгрөгийн өртөгтэй “Контейнерын хөргүүрийг засварлах” ТАХ-үүдээс дүгнэхэд ажлын байрны тодорхойлолтод заагдсан ажлыг бусдаар гүйцэтгүүлсэн, эдийн засгийн тооцоолол, судалгаа, шинжилгээ хийж, мэдээллийг хангалттай цуглуулалгүй ТАХ-г хэрэгжүүлэн, төсвийн хөрөнгийг үр ашиггүй, үр дүнгүй, хэмнэлтгүй зарцуулсан байна.

Иймд сумдын Засаг дарга нарт эдийн засгийн тооцоо судалгаатай, үр ашигтай, хэрэгжих боломжтой төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллах зөвлөмжийг хүргүүлж байна.



Харин аймгийн хэмжээнд 2024 онд бүрэн хэрэгжсэн 10,330.2 сая төгрөгийн 228 арга хэмжээнээс 1,670.6 сая төгрөгийн 24 ТАХ нь боловсролын байгууллагуудын гадна, доторх орчны тохижилт, хүүхэд, багачуудын хичээлийн сургалтын хэрэглэгдэхүүн, тоног, төхөөрөмжийг нэмэгдүүлсэн ТАХ-нууд байна. Уг ТАХ-нууд хэрэгжсэнээр хот, хөдөөгийн боловсролын байгууллагуудын хоорондын ялгааг бууруулж, тэгш хүртээмжийг ханган, сургалтын орчныг аюулгүй, тав тухтай болгож, орчин үеийн сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэн сурагчдын суралцах идэвх, хандлага сайжирч, сурлагын чанарыг дээшлүүлж, эерэг нөлөө үзүүлж байна.

Аймгийн хэмжээнд 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр нийт 364 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталснаас 252 төсөл, арга хэмжээний гэрээ хийгдсэн байна. Үүний 87.7 хувь буюу 228 төсөл, арга хэмжээ бүрэн дууссан боловч 21 төсөл арга хэмжээ гүйцэтгэл дутуу, 3,699.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгож дараа онд шилжсэн байна.

Сайхан-овоо сум 20.0 сая төгрөгийн өртөгтэй “Зүүн лагерийн худгийг байшинтай болгож, смарт төхөөрөмж суурилуулах” ТАХ хэрэгжсэн боловч зүүн лагерт эрчим хүч сайжруулах ажлын тендер амжилтгүй болсон тул уг цахим худгийг огт ашиглаагүй байна.

Дээрх нөхцөл байдлаас харахад захиалагч шаардлагатай байгаа тоног төхөөрөмжийн техник тодорхойлолтоо орчин нөхцөлтэйгөө уялдуулан судалгаа шинжилгээ хийхгүйгээр гаргасан нь орон нутгийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж, ашиглалтгүй хөрөнгүүдийг бэлтгэх үндэс болж байна.

Иймд Зүүн лагерийн эрчим хүчнийг сайжруулах ажлыг эрчимжүүлж, цахим худгийг ашиглах нөхцөл боломжийг бүрдүүлэн, зориулалтын дагуу ашиглах зөвлөмжийг Сайхан-овоо сумын Засаг даргад хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Аудитаар ОНХС-аар бэлтгэсэн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалттай холбоотой илэрсэн асуудлыг дурдвал:

- Сайнцагаан сумын ОНХС-аар хийгдсэн 109.6 сая төгрөгийн өртөгтэй “Төвийн багуудын танилцуулга, гэрэлт самбарын байгууламж барих ажил” хийгдсэн боловч байгууламжийн толгойн зарим хэсэг нь унасан.
- Сайнцагаан сумын ОНХС-аар хийгдсэн 407.9 сая төгрөгийн өртөгтэй /БМБХ ШТС-аас Шунхлай ШТС хүртэлх/ 3.5 км улсын чанартай авто замын гэрэлтүүлгийн ажлыг шалгахад нэг шонг машин дайрсан, зарим гэрлийн толгойн хүрээ эвдэрсэн;

Дээрх байдлаас харахад зарим эзэмшигч байгууллагуудын хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт муу байгаагаас хөрөнгийг засаж сэлбэх шаардлага үүсэж, төсвийн зардлыг нэмэгдүүлэх эрсдэлийг бий болгож байна.

Иймд 2024 онд бэлтгэсэн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт хэрэгжүүлж, ашиглалтын явцад үүссэн эвдрэл гэмтлийг засварлах ажлыг гэрээний баталгаат хугацаанд гүйцэтгэгч байгууллагаар хийлгүүлэн, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах зөвлөмжийг Сайнцагаан сумын Засаг даргад хүргүүлээ.

В. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж байгаа боловч иргэд олон нийтийг мэдээллээр хангах ажил хангалтгүй байсаар байна.



Аймаг, сумдын ИТХ-ын дэргэдэх хяналтын хороод нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ-ний хэрэгжилтийн явц болон гүйцэтгэлийн үр дүнд хяналтыг хэрэгжүүлж, дүгнэлт зөвлөмж өгсөн байна. Тухайлбал Баянжаргалан, Гурвансайхан, Дэлгэрхангай, Дэлгэрцогт сумдын хяналтын хороод нь захиалагчийн хяналт хийх, хэрэгжилтийн ил тод байдлыг олон нийтэд бүрэн мэдээлэх, ажил хариуцсан албан тушаалтны ажлын хариуцлагыг сайжруулах, хэрэгжээгүй болон дутуу, чанаргүй хийгдсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг сайжруулах зэрэг нийтлэг зөвлөмжүүдийг хүргүүлжээ. Харин бусад сумдын ИТХ-ын дэргэдэх хяналтын хороод хяналт хийж, дүгнэлт гаргасан боловч тухайлсан зөвлөмж өгөөгүй байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас Дэрэн, Дэлгэрцогт, Говь-Угтаал сумдын ОНХС-ийн санхүүгийн үйл ажиллагаанд батлагдсан удирдамжийн дагуу санхүүгийн төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж, сангийн үйл ажиллагаа хууль журмын дагуу ажилласан гэсэн дүгнэлт өгсөн байна.

Аймгийн хэмжээнд 13,886.0 сая төгрөгийн 252 арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхээс 10,224.1 сая төгрөгийн 233 ТАХ-д бүрэн хэрэгжүүлж, 1,443.8 сая төгрөгийн өртөгтэй 19 ТАХ-нд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Үүнээс мэргэжлийн байгууллагаар захиалагчийн хяналт хийлгэх шаардлагатай аймгийн ОНХС-2,981.8 сая төгрөгийн өртөгтэй 12 ТАХ-нд захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлсэн байна. Харин сумдын ОНХС-ийн 2,923.0 сая төгрөгийн өртөгтэй 15 ТАХ-нд захиалагчийн хяналтыг хийлгэж, 13,062.0 сая төгрөгийн өртөгтэй 19 ТАХ-д захиалагчийн хяналт хийлгээгүй нь Барилгын тухай хуулийн 37.2⁶-т заасныг зөрчсөн байна.

Эндээс харахад ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан ТАХ-нд захиалагчийн хяналт хэрэгжүүлэхдээ мэргэжлийн байгууллагаар хянуулаагүйгээс хяналтын үр дүн төдийлөн хангалтгүй байна. Энэ нь хөрөнгө оруулалт, ТАХ хугацаандаа хэрэгжихгүй байх, чанарын шаардлага хангахгүй хөрөнгө бэлтгэгдэх, төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах эрсдэлийг бий болгосоор байна.

Иймд аймаг, суманд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа ТАХ-ний захиалагчийн хяналтыг холбогдох мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах албан шаардлагыг аймгийн Засаг дарга хүргүүлээ.

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар зөрчил арилгах, ажил сайжруулахаар 3 зөвлөмж, 6 албан шаардлага хүргүүлсэн. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлт 67.0 хувьтай хангалтгүй байна. Өөрөөр хэлбэл төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнг холбогдох хууль, журамд заасны

⁶ Захиалагч барилгын үйл ажиллагаанд оролцох өөрийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэн, мэргэжлийн хуулийн этгээдээр төлөөлүүлэн хэрэгжүүлж болно

дагуу олон нийтэд нээлттэй ил тод мэдээлэх ажил хангалтгүй байна. Тухайлбал УМС-д мэдээлэх мэдээллийг 7 сум дутуу буюу огт мэдээлээгүй, Шилэн дансны цахим хуудсанд 5 сум дутуу буюу огт мэдээлээгүй, мэргэжлийн байгууллагаар захиалагчийн хяналт хийлгэх шаардлагатай 19 ТАХ байна.

Иймд өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг заасан хугацаанд хэрэгжүүлээгүй тул зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлсэн.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудад төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг санхүүгийн тайлан, бүртгэлд тусгахаар заасны дагуу ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон нийт 13,886.0 сая төгрөгийн 252 ТАХ-нээс 9,072.4 сая төгрөгийн 180 ТАХ-г аймаг, сумдын ИТХ-ын тогтоол, байгууллагын даргын тушаал шийдвэрийг үндэслэн хөрөнгийн дансанд, 1,388.1 сая төгрөгийн 72 төсөл, арга хэмжээг урсгал зардлаар тайлагнасан байна. Харин 3,425.5 сая төгрөгийн 21 ТАХ он дамжуулан гүйцэтгэгдэж байгаагаас шалтгаалан авлагаар тусгасан байна.

Удирдлага мэдээллийн системд мэдээллийг үнэн зөв, бүрэн оруулаагүйгээс иргэд, олон нийт мэдээллийг тухай бүр авч чадахгүй байна. Тухайлбал тайлант онд аймгийн хэмжээнд УМС-д ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэх 22,333.2 сая төгрөгийн 364 төсөл, арга хэмжээг мэдээлэхээс гүйцэтгэлээр 13,471.0 сая төгрөгийн 186 төсөл, арга хэмжээний мэдээллийг бүрэн оруулсан байна. Харин 5,498.1 сая төгрөгийн 107 төсөл, арга хэмжээг дутуу, 3,364.0 сая төгрөгийн 71 төсөл, арга хэмжээг огт оруулаагүй байна.

Энэ нь ОНХС-ийн УМС-ийн хэрэгжилт цэсэд хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаарх мэдээллийг оруулж, оруулсан мэдээллийн дагуу санхүүжилтийг хийгээгүйтэй холбоотой байна.

Иймд ОНХС-ийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилтийн талаарх мэдээллийг удирдлагын мэдээллийн системд бүрэн оруулж, оруулсан мэдээллийн дагуу санхүүжилтийг олгож хэвшүүлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж ажиллах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлээ.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд аймаг, сумдын ОНХС-ийн мэдээллийг байршуулаагүй зөрчил бүрэн арилахгүй байна. Тухайлбал 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар аймгийн төв 75, Өлзийт 15, Луус 5 мэдээлэл хугацаа хоцроосон бол Сайхан-Овоо 33, Өлзийт 28 мэдээллийг огт байршуулаагүй зөрчил илэрсэн байна.

Дээрх Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1⁷, 4.1.3⁸-т заасныг бүрэн хэрэгжүүлээгүй зөрчлүүд нь иргэд, олон нийтийг буруу мэдээллээр хангах нөхцөлийг бий болгож байна.

Иймд Шилэн дансны цахим хуудсанд үнэн зөв, иж бүрэн байршуулсан эсэхэд хяналт тавьж, хуульд заасан үүргээ хэрэгжүүлж, биелэлтийг хангуулж ажиллах асуудлаар аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт албан шаардлага хүргүүлээ.

⁷ мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх

⁸ тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх

Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Хандив, тусламжийн орлогыг ОНХС-д төвлөрүүлж, зарцуулах эрх зүйн орчин бүрдсэн боловч аймгийн ОНХС болон Баянжаргалан, Дэлгэрцогт сумдаас бусад төсвийн захирагч нар тус орлогын эх үүсвэрийг төлөвлөөгүй, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.
2. Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангаагүй ТАХ-г хэрэгжүүлэхээр, төлөвлөж, баталдаг зөрчил гарсаар байна.
3. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаас зайлсхийж, багцад хуваан шууд худалдан авалт хийдэг зөрчил илэрсээр байна.
4. Тайлант онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн зарим төсөл, арга хэмжээ үр дүнтэй байна.
5. Зарим хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хангалтгүй, хяналт сул байна.
6. Мэргэжлийн байгууллагаар хийлгэх шаардлагатай захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэхгүй байна.
7. Өмнөх аудитаар өгөгдсөн зөрчил арилгуулах албан шаардлага, зөвлөмжийн биелэлт 67.0 хувьтай хангалтгүй байна.
8. Удирдлага мэдээллийн системд ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэх 5,498.1 сая төгрөгийн 107 төсөл, арга хэмжээг дутуу, 3,364.0 сая төгрөгийн 71 төсөл, арга хэмжээг огт оруулаагүй байна.
9. ОНХС-гийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж Сангийн яаманд хүргүүлсэн байна.
10. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд аймаг, сумдын ОНХС-ийн мэдээллийг байршуулаагүй зөрчил бүрэн арилахгүй байна.

Зөвлөмж

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн Засаг даргад:

1. Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид нийцсэн, шалгуур үзүүлэлт хангасан, эдийн засгийн үр ашигтай, ард иргэдэд үр өгөөжтэй, нэн тэргүүний ач холбогдолтой ТАХ-г орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан батлуулах;

Сайхан-Овоо сумын Засаг даргад:

1. Зүүн лагерын эрчим хүчнийг сайжруулах ажлыг эрчимжүүлж, цахим худгийг ашиглалтад оруулах;

Сайнцагаан сумын Засаг даргад:

1. Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлсэн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт хэрэгжүүлж, ашиглалтын явцад үүссэн эвдрэл гэмтлийг засварлах ажлыг гэрээний баталгаат хугацаанд гүйцэтгэгч байгууллагаар хийлгүүлэх, хадгалалт хамгаалалтыг сайжруулах;

Монгол Улс, Дундговь аймаг 48090, Сайнцагаан сүм, Нарлаг
баг, Нутгийн удирдлагын ордон Утас/Факс: 70-59-24-39
E-mail: dundgovi@audit.gov.mn ᠓ᠨ